

## 2013 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН ДААТГАЛЫН МЭДЭЭ

2013 оны 10 дугаар сарын 21

### 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2013 оны 9 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2013.09.01	Нэмэгдсэн	Хасагдсан	/тоогоор/
					2013.09.30
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	240			240
3	Даатгалын төлөөлөгч	3136	7 <sup>1</sup>		3143
4	Даатгалын зуучлагч	20	1 <sup>2</sup>	2 <sup>3</sup>	19
5	Даатгалын хохирол үнэлэгч	11			11
6	Актуарч	15			15
7	Жолоочийн даатгалын зөвшөөрөл	16			16
8	Даатгалын зуучлагч компанийн салбар	36			36
9	Даатгалын компанийн төлөөлөгчийн газар	6			6

<sup>1</sup>Хорооны даргын 2013 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 216 дугаар тушаалаар “Монре даатгал” ХХК-ийн 7 иргэнд даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг олгосон байна.

<sup>2</sup>Хорооны 2013 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 296 дугаар тогтоолоор “Төрийн банк” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

<sup>3</sup>Хорооны 2013 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 292 дүгээр тогтоолоор “Жомолхари” ХХК-ийн, мөн өдрийн 295 дугаар тогтоолоор “Хадгаламж банк” ХХК-ийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон байна.

### 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2013 оны 9 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сарын болон өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

**Ердийн даатгалын компаниудын хувьд :**

	/төгрөгөөр/	
Үзүүлэлт	2013.09.30	2013.09.30
	/сарын дүн/	/өссөн дүн/

Даатгалын нийт хураамж	9,265,450,046.26	60,653,526,542.12
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж	1,046,069,108.68	10,860,587,367.51
Олгосон нийт нөхөн төлбөр	2,116,847,350.72	18,446,588,103.63
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	893,495,955.80	7,008,243,901.57
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	1,959.00	15,791.00
Давхар даатгалд төлсөн хураамж	5,880,479,809.63	16,773,987,401.43
Байгуулсан даатгалын гэрээний тоо	43,948.00	443,590.00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	23,527.00	213,316.00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	31,908.00	254,146.00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	6,644,894,519,874.00	6,644,894,519,874.00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр	35,255,156.00	35,255,156.00

2013 оны 9 дүгээр сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хураамжийн орлого 60653.5 сая төгрөг, үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж 10860.6 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 18446.6 сая төгрөг ба үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 7008.2 сая төгрөг болсон байна. Эндээс даатгалын хохирол нөхөлтийн түвшин сарын байдлаар 22.9 хувь, өссөн дүнгээр 30.5 хувь болсон бөгөөд өмнөх сарын мөн үеийнхээс сарын байдлаар 5.6 пунктээр, өссөн дүнгээр 1.3 пунктээр тус тус буурсан байна.

#### Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

Үзүүлэлт	2013.09.30 /сарын дүн/	/төгрөгөөр/ 2013.09.30 /өссөн дүн/
Даатгалын нийт хураамж	93,310,682.00	683 196 945.00
Олгосон нийт нөхөн төлбөр	13,943,355.00	137 191 902.00
Давхар даатгалд төлсөн хураамж	2,254,431.00	35 976 480.00
Байгуулсан даатгалын гэрээний тоо	10.00	164.00
Хувь хүний хугацаат даатгалд		32.00
Байгууллагын хугацаат даатгалд		17.00
Өндөр хамгаалалттай ЭМД-д	2.00	2.00
Эмнэлгийн мөнгөний даатгалд	2.00	28.00
Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	3.00	3.00
Тэтгэврийн даатгалд		4.00

Орон сууцны даатгалд	1.00	3.00
Хуримтлалын даатгалд		
Зээлдэгчийн амь насны даатгалд	2.00	20.00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	747,330.00	20,000,000.00

Урт хугацааны даатгагч 2013 оны 9 дүгээр сарын байдлаар /өссөн дүнгээр/ 683.2 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой, 137.2 сая төгрөгийг нөхөн төлбөрт олгосон байна. Даатгалын нөхөн олговрын түвшин 20.1 хувьтай байна.

**Даатгалын зуучлагч компаниудын хувьд :**

	/төгрөгөөр/	
Үзүүлэлт	2013.09.30 /сарын дүн/	2013.09.30 /өссөн дүн/
Нийт орлого	15,143,733,317.94	50,605,012,697.84
Даатгалын зуучлагчийн орлого	162,349,702.94	427,396,020.97
Үүнээс: Сайн дурын даатгал	95,620,738.24	333,698,987.31
Албан журмын даатгал	66,728,964.70	82,001,707.70
Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	369,565,356.00	824,833,448.88
Зуучилсан даатгалын гэрээний тоо	8,406.00	12,534.00
Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ	1,880,223,643.00	1,880,223,643.00

2013 оны 9 дүгээр сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын зуучлагч компаниуд 427.4 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Үүний 78.1 хувийг сайн дурын даатгалаас үлдсэн хувийг албан журмын даатгалын хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна. “Аме” ХХК-ийн зуучилсан гэрээ даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр 1880.2 сая төгрөгийн үнэлгээтэй байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Эм жи ай би” ХХК, “Си эн эн икс” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

“Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Изи инвестмэнт” ХХК, ХХК, “Нэйшнл эженси” ХХК, “Гэрэлт буян ундрах” ХХК, “Юу ай би” ХХК, “Эс би ай эс” тус тус 9 дүгээр сарын мэдээг тус тус ирүүлээгүй байна.

**Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :**

	/төгрөгөөр/	
Үзүүлэлт	2013.09.30 /сарын дүн/	2013.09.30 /өссөн дүн/

Нийт орлого	45,729,708.55	287,841,763.01
Даатгалын хохирол үнэлгээний орлого	36,041,981.73	154,798,399.29
Үүнээс: Сайн дурын даатгал	6,106,636.36	55,506,068.55
Албан журмын даатгал	23,419,890.37	92,776,874.74
Үнэлсэн даатгалын хохирлын тоо	1,363.00	9,580.00
Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	105,944,481.00	263,358,888.00

2013 оны 9 дүгээр сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хохирол үнэлэгч компаниуд 287.8 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс 35.9 хувийг сайн дурын, 58.4 хувийг албан журмын даатгалын хохиролын үнэлгээний орлогоос төвлөрүүлсэн байна.

“Ашид билгүүн” ХХК, “Тэгш сонголт эстимэйт” ХХК, “Файн эстимэйт” ХХК-иуд 9 дүгээр сарын мэдээг ирүүлээгүй байна.

### БУСАД

Хорооны 2013 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 293 дугаар тогтоолоор “Нэйшнл лайф даатгал” ХХК-д насан туршийн даатгалын хэлбэрийн зөвшөөрөл нэмж олгосон байна.

Хорооны 2013 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 294 дүгээр тогтоолоор “Изи инвестмэнт” ХХК-ийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн байна.

### ДААТГАЛЫН ГАЗАР